



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/191

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20 Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн Хэрлэн суманд Коронавирусын цар тахлын тохиолдол нэмэгдэж гарч байгаатай холбогдуулан батлагдсан тохиолдлын ойрын болон дам хавьтлыг түргэн шуурхай илрүүлэх, тархалтыг таслан зогсоох зорилгоор 2021 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс 04 дүгээр сарын 25-ны өдрийг дуусталх хугацаанд Политехникийн коллеж, Хэрлэн сумын 1 дүгээр сургууль дээр Гамшгаас хамгаалах шуурхай штаб, хариу арга хэмжээний багийг вакуумжуулан ажиллахад шаардлагатай хоол хүнс, бичиг хэргийн материал, шуудан холбооны зардлыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 2,127,545 /хоёр сая нэг зуун хорин долоон мянга таван зуун дөчин тав/ төгрөгийг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011234

04 Аймгийн Засаг даргын 2021 оны
дугаар сарын 23 өдрийн А/Б/С
дугаар захирамжийн хавсралт



Хөрөнгө зарцуулалтын тооцоо

№	Байгууллагын нэр	Зардлын нэр төрөл			Дүн
		Хоол хүнс	Бичиг хэрэг	Холбооны зардал	
1	Онцгой байдлын газар /Политехникийн коллеж /	554,345	270,000	377,000	1201,345
2	Онцгой байдлын газар /Хэрлэн 1 дүгээр сургууль/	607,800	113,400		721,200
3	Эрүүл мэндийн газар /Аймгийн шуурхай штаб/		205,000		205,000
Нийт		1,162,145	588,400	377,000	2,127,945